

**Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар
хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээр**

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГОЛ АГУУЛГА:

Хоёр улсын иргэдийг тэтгэврийн даатгалд давхар даатгуулахгүйгээр өөрийн улсын тэтгэврийн даатгалд даатгуулах, хэрэв даатгуулсан тохиолдолд Солонгосын үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох явдал юм.

Энэхүү хэлэлцээрээр БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэд өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн амьдралын нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, БНСУ-ын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Б. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХЭРЭГЛЭНЭ:

Монгол Улсын хувьд:

- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль,
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль.

Солонгос Улсын хувьд:

- Үндэсний тэтгэврийн тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийн даатгал болон үйлдвэрлэлийн ослын нөхөн олговрын даатгалын шимтгэлийн хуримтлалын тухай хууль, дээрх хуулиудад хамаарах дүрэм зааврууд.